

"МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО" НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

- 1.1. "Монголын сагсан бөмбөгийн холбоо" НҮТББ нь /цаашид "Холбоо" гэх/ сагсан бөмбөгийн спортыг сонирхогч, хичээллэгч, дэмжигчдийн хүсэл сонирхлын дагуу үйл ажиллагаагаа нэгтгэн чиглүүлэхээр сайн дурын үндсэн дээр үүсгэн байгуулагдсан, гишүүнчлэлтэй, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.
- 1.2. Холбооны албан ёсны нэр:

Монгол хэлээр бүтэн нэр нь "МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО" НҮТББ;
Монгол хэлээр товчилсон нэр нь "МСБХ";

Англи хэлээр бүтэн нэр нь "MONGOLIAN BASKETBALL ASSOCIATION" NGO;
Англи хэлээр товчилсон нэр нь "МБА" гэж нэрлэгдэнэ.
- 1.3. Холбооны үүсгэн байгуулагдсан он, сар, өдөр: 1994 оны 3 дугаар сарын 29-ны өдөр.
- 1.4. Холбоо нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бөгөөд Холбооны албан ёсны хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө, Монголын Үндэсний олимпын хорооны байр.
- 1.5. Холбоо нь өөрийн үйл ажиллагааны онцлогийг илэрхийлсэн бэлэгдэл бүхий тэмдэг, туг, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу үйлдсэн тэмдэг албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.
- 1.6. Холбоо нь Монгол Улсад мэргэжлийн болон сонирхогчдын сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх, энэхүү спорттой холбоотой аливаа үйл ажиллагааг зохион байгуулах албан ёсны байгууллага болно.
- 1.7. Холбоо нь нийслэл болон хөдөө орон нутагт, мөн түүнчлэн гадаад улсад өөрийн салбарыг нээн ажиллуулж болно.
- 1.8. Холбоо нь үйл ажиллагаа явуулах үүднээс өөрийн нэр дээр банкинд төгрөгийн болон валютын данстай байна.
- 1.9. Холбооны үйл ажиллагаа явуулах хугацааг дүрмээр хазгаарлахгүй.

Хоёрдугаар зүйл. Холбооны зорилго, үйл ажиллагааны чиглэл

- 2.1 Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд энэхүү дүрэмд заасан зорилго, чиглэлийнхээ дагуу үйл ажиллагаагаа тогтвортой явуулна.

- 2.2 Холбооны зорилго нь Монгол Улсад сагсан бөмбөгийн спортыг бүх нийтийн хүртээл болгох, мэргэжлийн болон сонирхогчдын сагсан бөмбөгийн спортыг олон нийтэд сурталчлан таниулах, хөгжүүлэхэд чиглэсэн идэвхитэй үйл ажиллагаа явуулах, олон улсын түвшинд өрсөлдөхүйц сагсан бөмбөгийн тамирчид, дасгалжуулагч, шүүгчдийг сурган бэлтгэх, амжилтыг нь ахиулахад оршино.
- 2.3 Холбоо нь Монголын Үндэсний олимпийн хороо /цаашид "МҮОХ" гэх/-ны гишүүн бөгөөд олимпийн үзэл санааг дэмжиж, үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцоно.
- 2.4 Холбоо нь Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/, Азийн сагсан бөмбөгийн холбоо /FIBA Asia/-ны албан ёсны гишүүн бөгөөд үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцоно.
- 2.5 Холбоо нь бусад улсын сагсан бөмбөгийн холбоо, спортын байгууллагуудтай мэргэжлийн болон сонирхогчдын сагсан бөмбөгийн чиглэлээр харилцаа тогтоож, гэрээ байгуулах, хамтран ажиллах бүрэн эрхтэй байна.
- 2.6 Холбоо нь энэ дүрэмд заасан зорилго, чиглэлд үл нийцэх ажиллагааг явуулахгүй, түүнд оролцохгүй бөгөөд хууль бус, нийтээр хулээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахгүй, түүнд оролцохгүй байх, ил болон далдаар дэмжихгүй.
- 2.7 Холбоо нь өөрийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлийн үйл ажиллагааг явуулна. Үүнд:
 - 2.7.1. Сагсан бөмбөгийн спортыг сонирхогч, хичээллэгч, дэмжигчийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, удирдан чиглүүлэх;
 - 2.7.2. Монгол Улсын сагсан бөмбөгийн спортын хөгжлийг олон улсын түвшинд хүргэх;
 - 2.7.3. Сагсан бөмбөгийн спортыг олон нийтэд сурталчлан таниулах;
 - 2.7.4. Уралдаан тэмцээн зохион байгуулах;
 - 2.7.5. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах;
 - 2.7.6. Сургалт, дасгалжуулалтыг явуулах нөхцлийг бүрдүүлэх;
 - 2.7.7. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллах;
 - 2.7.8. Холбооны үйл ажиллагааны зорилгод нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;
 - 2.7.9. Сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд шаардлагатай суурийг бүрдүүлэх;
 - 2.7.10. Нийгэмд чиглэсэн сайн санааны үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжих;
 - 2.7.11. Хуулиар хорилгоогүй бусад үйл ажиллагаа.
- 2.8. Дээрх чиглэлийн үйл ажиллагаануудын хүрээнд энэ дүрмийн 4 дүгээр зүйлийн Холбооны эрх, үүрэгт заасан тодорхой үйл ажиллагаануудыг эрхлэн явуулж, зохион байгуулж оролцоно.

Гуравдугаар зүйл. Холбооны үйл ажиллагаанд мөрдөх зарчим

- 3.1. Холбоо нь үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:
 - 3.1.1. Холбоо нь Олимпын үзэл санааг өөрийн үйл ажиллагаагаар тууштай дэмжинэ;
 - 3.1.2. Холбооны үйл ажиллагаа нь гишүүддээ болон олон нийтэд ил тод, нээлттэй байна;
 - 3.1.3. Холбооны үйл ажиллагаа нь нийгэмд чиглэсэн ашгийн төлөө бус байна;
 - 3.1.4. Холбоо нь олон нийтийн болон гишүүдийнхээ ашиг сонирхлыг өөрийн үйл ажиллагаандаа удирдлага болгоно;

- 3.1.5. Холбоо нь үйл ажиллагаагаа удирдан зохион байгуулахдаа эрх тэгш, хамтын удирдлагын зарчмыг тууштай баримтлана;
- 3.1.6. Холбоо нь өөрийн үйл ажиллагаагаа бие даан удирдан зохион байгуулах бөгөөд аливаа хөндлөнгийн этгээдийн нөлөөлөлд автахгүй, хөндлөнгийн этгээдийн нөлөөллөөс ангид байна;
- 3.1.7. Холбооны үйл ажиллагаа нь хэн нэгний яс үндэс, хүйс, нийгмийн гарал, шашин шүтлэг, үзэл бодол, алдар цолоор ялгаварласан шинжтэй байж болохгүй;
- 3.1.8. Холбооны үйл ажиллагаанд нөхөрсөг, нэгдмэл байдлыг эрхэмлэж, сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх аливаа санал, санаачлагыг хөхүүлэн дэмжинэ;
- 3.1.9. Холбооны гишүүд удирдлага, ажилтнууд нь Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/ болон өөрийн баталсан дүрэм журам, удирдамж, шийдвэр, ёс зүйн хэм хэмжээг чанд баримтална;
- 3.1.10. Дэлхийн допингийн эсрэг агентлаг /WADA/-аас батлан гаргасан Дэлхийн допингийн эсрэг дүрмийг үндэсний хэмжээнд чанд сахин мөрдөнө.

Дөрөвдүгээр зүйл. Холбооны эрх, үүрэг

- 4.1 Холбооны эрх үүргийг энэхүү дүрмийн 2 дугаар зүйлийн 2.7-д заасан үйл ажиллагааны чиглэл тус бүрээр тодорхойлно.
- 4.2 Холбоо нь сагсан бөмбөгийн спортыг сонирхогч, хичээллэгч, дэмжигчдийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, удирдан чиглүүлэх чиглэлийн хүрээнд:
 - 4.2.1. Сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд чиглэсэн үндэсний хэмжээний урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
 - 4.2.2. Тамирчид, дасгалжуулагч, шүүгч, мэргэжилтэн, сонирхогч дэмжигчдийн сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхтэй холбоотой хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
 - 4.2.3. Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/, Азийн сагсан бөмбөгийн холбоо /FIBA Asia/-ноос баталсан сагсан бөмбөгийн дүрэм болон Холбооны дүрэм, журмыг үндэсний хэмжээнд мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих;
 - 4.2.4. Холбооны үйл ажиллагааны хүрээнд мөрдөгдөх дүрэм, журмыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, өөрчлөн шинэчлэх, хэрэгжилтийг хангах, хяналт тавих;
 - 4.2.5. Холбооны бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөлийн хурал болон бусад хурал чуулганыг зохион байгуулах;
 - 4.2.6. Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч, шүүгч, мэргэжилтэн, сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан байгууллага, хувь хүнийг холбогдох спортын байгууллагын болон төрийн шагналд нэр дэвшүүлж тодорхойлох;
 - 4.2.7. Холбооны дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон тамирчны тэмцээнд оролцох, дасгалжуулагч, шүүгчийн ажиллах эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, эрхийг хасах зэрэг ёс зүйн арга хэмжээ авах.
- 4.3. Монгол Улсын сагсан бөмбөгийн спортын хөгжлийг олон улсын түвшинд хүргэх чиглэлийн хүрээнд:
 - 4.3.1. Монгол Улсын сагсан бөмбөгийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг өөрийн нэрийн өмнөөс мэдүүлэг өгч, батламжлан холбогдох ангиллын олон улсын тэмцээнд оролцуулах;

- 4.3.2. Сагсан бөмбөг сонирхогч, дэмжигч, багш, дасгалжуулагч, шүүгч нарын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, семинар, уулзалтыг зохион байгуулах;
 - 4.3.3. Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/, Азийн сагсан бөмбөгийн холбоо /FIBA Asia/ болон сагсан бөмбөгийн спортын олон улс байгууллагуудаас зохион байгуулах сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг өөрийн оронд хүлээн авч, зохион байгуулах;
 - 4.3.4. Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/, Азийн сагсан бөмбөгийн холбоо /FIBA Asia/ болон сагсан бөмбөгийн спортын олон улсын байгууллагуудын гишүүн байх, элсэн орох, гарах, нэгдэх, гишүүний татвар төлөх;
 - 4.3.5. Олон улсын хурал, зөвлөгөөнд төлөөлөгч болон ажиглагч оролцуулах, санал дэвшүүлэх.
- 4.4. Сагсан бөмбөгийн спортыг олон нийтэд сурталчлан таниулах чиглэлийн хүрээнд:
- 4.4.1. Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/, Азийн сагсан бөмбөгийн холбоо /FIBA Asia/-ноос баталсан сагсан бөмбөгийн дүрэм болон Холбооны дүрэм, журмыг олон нийтэд таниулах;
 - 4.4.2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон маркетингийн бусад арга хэрэгслийг ашиглан сагсан бөмбөгийн спортын талаар олон нийтэд мэдлэг, мэдээлэл хүргэх, сурталчилгаа явуулах;
 - 4.4.3. Холбооны веб хуудсыг ажиллуулан Холбооны гишүүд, сагсан бөмбөг сонирхогч, дэмжигчдэд цахим орчноор тухай бүр мэдээлэл хүргэх.
- 4.5. Уралдаан тэмцээн зохион байгуулах чиглэлийн хүрээнд:
- 4.5.1. Олон нийтийг хамарсан арга хэмжээ, орон нутаг, нийслэл, улсын хэмжээний сагсан бөмбөгийн уралдаан тэмцээний хуваарь гарган зохион байгуулах, дэмжин оролцох;
 - 4.5.2. Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/, Азийн сагсан бөмбөгийн холбоо /FIBA Asia/ болон бусад олон улсын сагсан бөмбөгийн байгууллагуудаас зохион байгуулах уралдаан тэмцээнийг өөрийн оронд хүлээн авч, зохион байгуулах.
- 4.6. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах чиглэлийн хүрээнд:
- 4.6.1. Холбоо нь сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд шаардлагатай эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулах эсхүл аливаа хувь хүн, хуулийн этгээдээс энэ талаар гаргасан санал санаачлагыг хөхүүлэн дэмжих бөгөөд судалгаа хийх явцад олон улсын туршлагаас суралцаж, сургалтын арга барилыг бий болгон хөгжүүлэх;
 - 4.6.2. Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг сургалт дасгалжуулалтад ашиглах, бодит нөхцлийг бүрдүүлэх;
 - 4.6.3. Гадаадын болон дотоодын шинжлэх ухааны байгууллага, судлаач нараас туршлага судлах.
- 4.7. Сургалт, дадлагажуулалтыг явуулах нөхцлийг бүрдүүлэх чиглэлийн хүрээнд:
- 4.7.1. Сургалт, дасгалжуулалтын арга зүйг боловсронгуй болгох, орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилт, сургалтын техник хэрэгслийг нэвтрүүлэхийг дэмжин ажиллах;
 - 4.7.2. Олон улсын сагсан бөмбөгийн холбооны төлөөлөгч болон бусад орны сагсан бөмбөгийн дасгалжуулагч, баг, тамирчид, шүүгч нарыг өөрийн оронд урьж туршлага солилцох, хамтарсан бэлтгэл, сургалтыг зохион байгуулах ажлыг дэмжин ажиллах.

- 4.8. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллах чиглэлийн хүрээнд:
- 4.8.1. Холбооны бие даасан байдлыг хангах, үйл ажиллагааг бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувь хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах;
 - 4.8.2. Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/, Азийн сагсан бөмбөгийн холбоо /FIBA Asia/ болон бусад улсын сагсан бөмбөгийн холбоо, спортын байгууллагуудтай мэргэжлийн болон сонирхогчдын сагсан бөмбөгийн чиглэлээр харилцаа тогтоож, хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг өрнүүлж, гадаад харилцааг хөгжүүлэх;
 - 4.8.3. Төрийн зүгээс сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд баримтлах бодлогыг тодорхойлоход мэргэжлийн байгууллагын хувьд идэвхи, санаачлагатай оролцож хамтран ажиллах;
 - 4.8.4. Бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх үйл ажиллагаанд харилцан ашигтай байх зарчмаар боломжит бүх хэлбэрээр татан оролцуулах;
 - 4.8.5. Олимпын хөдөлгөөнийг дэмжин МҮОХ болон бусад спортын холбоодтой хамтран ажиллах.
- 4.9. Холбооны үйл ажиллагааны зорилгод нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийн хүрээнд:
- 4.9.1. Холбооны бэлгэдэл, нэр, таних тэмдэг болон зохиогчийн эрхийн холбогдолтой оюуны бүтээлийг Монгол Улсын хуулийн хүрээнд олон нийтэд сурталчилж таниулах, худалдан борлуулах, олсон орлого, ашгийг дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд ашиглах;
 - 4.9.2. Уралдаан тэмцээнийг олон нийтэд хүргэх аудио, видео, фото хэрэгсэл, бусад технологийг ашигласан бичлэг, сурталчилгааны материалыг бусад байгууллага, иргэдтэй холбогдох гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд хамтран ашиглах.
- 4.10. Сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд шаардлагатай суурийг бүрдүүлэх чиглэлийн хүрээнд:
- 4.10.1. Холбоо нь сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд шаардлагатай материаллаг баазыг өөрийн нөөц бололцоо болон хамтын ажиллагааны үр дүнд бүрдүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллана.
- 4.11. Нийгэмд чиглэсэн сайн санааны үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжих чиглэлийн хүрээнд:
- 4.11.1. Холбоо нь нийгмийн хариуцлагын хүрээнд сайн санааны тоглолт арга хэмжээ, тэмцээн уралдааныг санаачлан зохион байгуулах буюу дэмжин оролцоно;
 - 4.11.2. Олон нийтэд сагсан бөмбөгийн спортоор дамжуулан шударга ёс, эв нэгдэл, соёл боловсрол, хүмүүнлэгийн үнэт зүйлс, хүмүүжлийн эерэг нөлөөллийг бий болгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ;
 - 4.11.3. Холбоо нь нийгэмд чиглэсэн сайн санааны үйлсийг дэмжих зорилгоор дэргэдээ сан байгуулж болно. Сангийн үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тусгайлан дүрмээр зохицуулна.

**Тавдугаар зүйл. Холбооны бүтэц, удирдлага зохион байгуулалт,
хяналтын тогтолцоо**

- 5.1. Холбооны удирдлагын тогтолцоо нь Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга гэсэн бүтэцтэй байна.
- 5.2. Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга болон бусад албан тушаалтнууд нь Холбооны нэр хүнд, тэмдэг, хэвлэмэл хуудсыг хувийн зорилгоор ашиглахыг хатуу хориглох ба хэрэв үүнийг зөрчиж бусдад хохирол учруулсан бол ийнхүү хохирол учруулсан албан тушаалтан хохирлыг бүрэн хариуцна. Холбоо нь албан тушаалтнуудын хууль бус, буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирлыг хариуцахгүй.
- 5.3. Холбооны үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг холбооны дэргэдэх Хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.

Зургаадугаар зүйл. Бүх гишүүдийн хурал, түүний эрх хэмжээ

- 6.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал байх бөгөөд Бүх гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бусаар хуралдана.
- 6.2. Холбооны гишүүнчлэл дараах хэлбэртэй байна. Үүнд:
 - 6.2.1. Үндсэн гишүүн /байгууллага/;
 - 6.2.2. Хүндэт гишүүн /хувь хүн/.
- 6.3. Үндсэн гишүүн нь Холбооны дүрэмд заасан эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн, сагсан бөмбөгийн чиглэлээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа эрхэлдэг, Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд албан ёсны бүртгэлтэй төрийн бус байгууллага байна. Холбооны гишүүнээр элсэх хүсэлтийг Холбооны Удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэж баталгаажуулна.
- 6.4. Бүх гишүүдийн ээлжит /цаашид "ээлжит хурал" гэх/ хурлыг жилд нэг удаа хуралдуулна. Удирдах зөвлөл жил бүрийн эхний улиралд багтаан ээлжит хурлын товыг зарлаж, зарласан хугацаанд нь хуралдуулна.
- 6.5. Удирдах зөвлөлийн олонхи гишүүд эсвэл Ерөнхийлөгчийн саналаар Бүх гишүүдийн ээлжит бус /цаашид "ээлжит бус хурал" гэх/ хурлыг зарлан хуралдуулж болно.
- 6.6. Ээлжит болон ээлжит бус хуралд оролцох нийт төлөөлөгчдийн тоо, Холбооны үндсэн гишүүн тус бүрт ноогдох төлөөлөгчдийн тоог Удирдах зөвлөлийн олонхийн саналаар батлах бөгөөд Холбооны үндсэн гишүүдийн төлөөлөл ээлжит болон ээлжит бус хурлын төлөөлөгчдөөр оролцоно.
- 6.7. Ээлжит болон ээлжит бус хурлын товыг 14-өөс доошгүй хоногийн өмнө Холбооны Удирдах зөвлөл тогтоож, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд зарлана.
- 6.8. Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудлыг тухайн хурлыг зарлах үндэслэл, хэлэлцэх асуудлын жагсаалтын хамт гаргасан байна.
- 6.9. Ээлжит болон ээлжит бус хурлын төлөөлөгчдийн олонхи хуралд ирснээр хурлын ирц хүчин төгөлдөр болно.

- 6.10. Ээлжит болон ээлжит бус хурлын ирц бүрдээгүй тохиолдолд Холбооны Ерөнхийлөгчийн шийдвэрээр 10-аас хэтрэхгүй хоногийн хугацаагаар хойшлуулж болно. Энэхүү шалтгаанаар хойшилсон хурал нь ирц харгалзахгүйгээр хуралдаж хуралд оролцсон төлөөлөгчдийн тоогоор хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэр нь хуралд оролцогсдын олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.
- 6.11. Ээлжит болон ээлжит бус хурлыг Холбооны Ерөнхийлөгч даргалах бөгөөд хурлын дэгийг танилцуулж хурлын төлөөлөгчдийн саналыг авч баталснаар хурлын явцыг удирдан зохион байгуулна.
- 6.12. Дараах асуудлыг зөвхөн Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэнэ. Үүнд:
- 6.12.1. Холбооны дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 6.12.2. Холбооны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх;
 - 6.12.3. Удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэх;
 - 6.12.4. Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэх;
 - 6.12.5. Холбоог татан буулгах, өөрчлөн байгуулах.
- 6.13. Бүх гишүүдийн хурлаар хуралд оролцож буй төлөөлөгчдийн олонхийн саналаар тухайн асуудлыг шийдвэрлэнэ.

Долоодугаар зүйл. Удирдах зөвлөл, түүний эрх үүрэг, хариуцлага

- 7.1. Удирдах зөвлөл нь Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт Холбооны үйл ажиллагааг удирдлагаар хангах, бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй хамтын удирдлагын байгууллага юм.
- 7.2. Удирдах зөвлөлийн бүтэц зохион байгуулалт:
- 7.2.1. Удирдах зөвлөл нь 9-13 тооны гишүүнтэй байх бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүдийг нэг удаа 6 жилээр сонгоно;
 - 7.2.2. Холбооны Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байна;
 - 7.2.3. Холбооны Дэд Ерөнхийлөгч болох 6 хүртэл хүн Удирдах зөвлөлийн гишүүн байна. Мөн ижил тооны Удирдах зөвлөлийн гишүүн нь Холбооны Үндсэн гишүүн болох сагсан бөмбөгийн чиглэлээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа эрхэлдэг, Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд албан ёсны бүртгэлтэй төрийн бус байгууллагын төлөөлөл байна;
 - 7.2.4. Удирдах зөвлөлийн хурал нь гишүүдийн олонхийн ирцээр хүчин төгөлдөр болох ба нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана;
 - 7.2.5. Удирдах зөвлөл нь шийдвэрээ илээр санал хурааж гаргана;
 - 7.2.6. Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон Удирдах зөвлөлийн гишүүн болох Холбооны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч сонгуульт хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон, эрүүл мэндийн хувьд хэвийн ажиллах боломжгүй болсон, хүндээр өвчилсөн нь эмнэлгийн магадлагаагаар тогтоогдсон, нас барсан, гадаад улсад удаан хугацаагаар явсан гэх мэт хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн хүсэлтээр татгалзсан тохиолдолд Бүх гишүүдийн хурлаар нөхөн сонгож томилно;
 - 7.2.7. Удирдах зөвлөлийн гишүүн нь тус бүр нэг саналын эрхтэй хуралд оролцох ба аливаа асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэхэд тэгш эрхтэй оролцоно;
 - 7.2.8. Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана;

7.2.9. Удирдах зөвлөлийн хурлыг тэмдэглэл хөтлөн баталгаажуулах ба хурлаас гарсан шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Удирдах зөвлөлийн тогтоолыг нийт гишүүдийн олонхи болон Холбооны Ерөнхийлөгч гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

7.3. Удирдах зөвлөлийн эрх:

- 7.3.1. Холбооны ээлжит болон ээлжит бус хурлыг зохих журмын дагуу зарлах, зохион байгуулах;
- 7.3.2. Холбооны салбар, хяналтын зөвлөл, шүүгчдийн зөвлөл, дасгалжуулагчдын зөвлөл, ёс зүйн зөвлөл болон бусад шаардлагатай хороо, алба, нэгжийг байгуулах, тухайн салбар, зөвлөл, хороо, алба, нэгжийн дарга, гишүүдийг сонгож томилох, чөлөөлөх, тэдгээрийн ажил үүргийн хуваарийг гаргаж удирдлагаар хангах;
- 7.3.3. Ерөнхийлөгчийн санал болгосноор Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх, эрх хэмжээг тогтоох, үйл ажиллагаанд хяналт тавих, тайланг хэлэлцэх;
- 7.3.4. Холбооны дотоод журам, хөдөлмөрийн дотоод журам, хяналтын зөвлөл, ёс зүйн зөвлөл, шүүгчдийн зөвлөл, дасгалжуулагчдын зөвлөлийн журам болон тэмцээн уралдаан зохион байгуулах журам, шагнаж урамшуулах журам, тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдийн түвшинг тогтоох, сонгон шалгаруулах журам, ёс зүйн дүрэм зэргийг боловсруулж батлах;
- 7.3.5. Спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч, шүүгч, мэргэжилтэн, сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан хуулийн этгээд, хувь хүнийг холбогдох спортын байгууллагын болон төрийн шагналд тодорхойлох;
- 7.3.6. Олон улсын шугамаар зохион байгуулж буй арга хэмжээнд оролцуулах Холбооны төлөөлөгчид, баг тамирчдыг сонгох, томилох;
- 7.3.7. Холбооны бэлгэдэл, шагнал, медалийн загварыг батлах;
- 7.3.8. Холбооны гишүүнтэй холбоотой журмыг батлах, шинээр гишүүн элсүүлэх, гишүүнээс хасах асуудлыг шийдвэрлэх.

7.4. Удирдах зөвлөлийн үүрэг:

- 7.4.1. Шаардлагатай нөхцөлд Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах, дүрмийн төсөл боловсруулах;
- 7.4.2. Өөрийн бүрэн эрхийн хүрээнд тэмцээн зохион байгуулах талаар шийдвэр гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавих;
- 7.4.3. Жил бүрийн эцэст Холбооны үйл ажиллагааны чиглэл, цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан Холбооны ирэх жилийн төсөв төлөвлөгөө, дотоодод тэмцээн уралдаан зохион байгуулах, гадаадын тэмцээн уралдаанд оролцох нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг батлах;
- 7.4.4. Холбооны хяналтын зөвлөл, шүүгчдийн зөвлөл, дасгалжуулагчдын зөвлөл, ёс зүйн зөвлөл, салбар, хороо, алба, нэгжийн бүтэц, дотоод зохион байгуулалт, орон тоо, гишүүд дарга нар болон төсвийг батлан ажиллагсдын цалингийн хэмжээг тогтоох;
- 7.4.5. Холбооны удирдлагын бүтэц, дотоод зохион байгуулалт, орон тоо, төсвийг батлан ажиллагсдын цалингийн хэмжээг тогтоох;
- 7.4.6. Холбооны үйл ажиллагааг дүрэмд заасан зорилго, үйл ажиллагааны чиглэлдээ нийцүүлэн хэвийн тогтвортой явуулах нөхцлөөр хангах;
- 7.4.7. Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч болон Ерөнхий нарийн бичгийн даргын эрх хэмжээг тогтоон, үйл ажиллагаанд хяналт тавих;
- 7.4.8. Холбооны өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар эрх бүхий албан тушаалтнуудын эрх хэмжээг тогтоох;
- 7.4.9. Холбооны гишүүний жилийн татварын хэмжээг тогтоох;
- 7.4.10. Холбооны Ерөнхийлөгчийн ажлын тайланг хянах, батлах;

- 7.4.11. Холбооны үйл ажиллагаанд зайлшгүй мөрдөгдөх дүрэм, журам, зааврыг боловсруулан батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;
- 7.4.12. Олон улсын тэмцээн, арга хэмжээнд оролцох тамирчин, дасгалжуулагч, мэргэжилтэн, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг тогтоох;
- 7.4.13. Холбооноос шалгаруулах оны шилдгүүдэд олгох болон бусад шагнал урамшуулал, мөнгөн шагналын хэмжээг хэлэлцэж батлах;
- 7.4.14. Хүндэт ерөнхийлөгч, Хүндэт гишүүний цол өргөмжлөлийг олгох эсэхийг шийдвэрлэх;
- 7.4.15. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч тус бүр Холбооны үйл ажиллагаанд зориулан тухайн жилд хандивлах хандивын хэмжээг тогтоох;
- 7.4.16. Хуулиар олгогдсон бусад үүргийг хүлээнэ.

7.5. Удирдах зөвлөлийн гишүүд нь үүрэгт ажлаа гүйцэтгэхэд гарсан зардлын нөхөн төлбөрөөс бусад аливаа цалин, урамшууллыг Холбооноос авахгүй.

7.6. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь Удирдах зөвлөлийн хурал байна.

Наймдугаар зүйл. Ерөнхийлөгч, түүний эрх үүрэг, хариуцлага

8.1. Холбооны Ерөнхийлөгчийг Бүх гишүүдийн хурлын нийт төлөөлөгчдийн олонхийн саналаар нэг удаа 6 жилийн хугацаагаар сонгох ба түүний эрх хэмжээ, үйл ажиллагааны журмыг Удирдах зөвлөл батлана.

8.2. Ерөнхийлөгч нь Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн байх бөгөөд Холбооны Удирдах зөвлөлийн дарга байна.

8.3. Холбооны Ерөнхийлөгчийн эрх:

- 8.3.1. Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэх хүнийг сонгож Удирдах зөвлөлд санал оруулах;
- 8.3.2. Холбоог гадаад, дотоодын харилцаанд Удирдах зөвлөлөөс олгосон эрх, үүргийн хуваарийн хүрээнд төлөөлөх;
- 8.3.3. Удирдах зөвлөлийн хурлын товыг зарлах, мэдэгдэх, хурлыг даргалан явуулах, хурлыг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангах;
- 8.3.4. Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэж хуулийн этгээд, хувь хүн, олон улсын байгууллагатай гэрээ хэлэлцээр байгуулах, санхүүгийн баримтанд гарын үсэг зурах.

8.4. Холбооны Ерөнхийлөгчийн үүрэг:

- 8.4.1. Холбооны зорилгыг биелүүлэхэд чиглэсэн бодлого, төлөвлөгөө боловсруулж Удирдах зөвлөлд танилцуулах, батлагдсан төлөвлөгөөг мөрдөж ажиллах;
- 8.4.2. Удирдах зөвлөл, Бүх гишүүдийн хуралд ажлаа тайлагнах;
- 8.4.3. Холбоо болон түүний гишүүд, дэмжигч нарын хоорондох харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 8.4.4. Төрийн болон төрийн бус байгуулага, Олон улсын сагсан бөмбөгийн холбоо /FIBA/, Азийн сагсан бөмбөгийн холбоо /FIBA Asia/ болон бусад олон улсын байгууллага, хуулийн этгээд, хувь хүнтэй Холбооны зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу хоёр ба олон талт харилцаа, хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэх.

8.5. Холбооны Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх:

- 8.5.1. Ерөнхийлөгчийн сонгуульт хугацаа дууссан, дүрмийн бус үйл ажиллагаа явуулсан, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон, эрүүл мэндийн хувьд хэвийн ажиллах боломжгүй болсон нь эмнэлгийн магадлагаагаар тогтоогдсон, өөрийн хүсэлтээр татгалзсан үндэслэлээр үүрэгт ажлаас нь Удирдах зөвлөлийн шийдвэрээр чөлөөлнө;
- 8.5.2. Ерөнхийлөгч сонгуульт хугацаанаас өмнө ажил үүргээ биелүүлэх боломжгүй болсон нөхцөлд түүнийг орлох үүрэг гүйцэтгэгчийг Удирдах зөвлөл, Дэд ерөнхийлөгчийн дундаас сонгон томилох бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ, үйл ажиллагааны журмыг Удирдах зөвлөл батлана.

8.6. Холбооны Ерөнхийлөгч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрмийн зүйл заалтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд түүнээс үүдэн гарах аливаа хариуцлагыг бүрэн хүлээнэ.

Есдүгээр зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга, түүний эрх, үүрэг, хариуцлага

- 9.1. Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгч санал болгосноор Удирдах зөвлөл томилох бөгөөд Холбооны орон тооны ажилтан байна.
- 9.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь өөрийн ажлын албыг байгуулж болно.
- 9.3. Ерөнхий нарийн бичгийн даргын шийдвэр нь тушаал хэлбэртэй байна.
- 9.4. Ерөнхий нарийн бичгийн даргын эрх:
 - 9.4.1. Удирдах зөвлөлөөс тогтоосон эрхийн хүрээнд шийдвэр гаргах, гэрээ болон санхүүгийн баримтанд гарын үсэг зурах;
 - 9.4.2. Удирдах зөвлөлд ажлаа тайлганах, санал оруулах;
 - 9.4.3. Холбооны Бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, Холбооны дэргэдэх бусад хуралд оролцох;
 - 9.4.4. Холбоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллах ажилчидтай Холбоог төлөөлөн гэрээ байгуулах.
- 9.5. Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг:
 - 9.5.1. Холбооны тухайн жилийн ажлын төлөвлөгөө болон санхүүгийн төсөв, бүтцийн талаар санал болон бодлогын чанартай бичиг баримтыг боловсруулан Удирдах зөвлөлд оруулах;
 - 9.5.2. Удирдах зөвлөл хэлэлцэн баталсан бүтэц, зохион байгуулалт, төсөв төлөвлөгөөний хүрээнд ажиллах;
 - 9.5.3. Холбооны өдөр тутмын ажлыг бүрэн хариуцаж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах;
 - 9.5.4. Тамирчид сэргээш хэрэглэхээс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулах;
 - 9.5.5. Холбооны үйл ажиллагаатай холбоотой албан бичиг, баримтыг бэлтгэж боловсруулах ба эх хувийг архивлан хадгалах;
 - 9.5.6. Холбооны тэмдэг, туг далбаа, хэвлэмэл хуудас, бичиг баримт, бусад зүйлсийг үйл ажиллагаандаа ашиглах, хадгалах, хамгаалах, архивлах, өмч хөрөнгийг бүртгэн хяналт тавих;
 - 9.5.7. Жилийн ажлын болон санхүүгийн тайлан тэнцлийг гаргуулж, Удирдах зөвлөлийн хуралд оруулах;
 - 9.5.8. Гадаад, дотоодод зохион байгуулагдах тэмцээнийг хариуцаж ажиллах.

Аравдугаар зүйл. Холбооны дэргэдэх зөвлөл, түүний эрх, үүрэг

- 10.1. Холбоо нь өөрийн зорилго, чиглэлд нийцсэн үйл ажиллагаа явуулах үүднээс дэргэдээ хяналтын зөвлөл, ёс зүйн зөвлөл, шүүгчдийн зөвлөл, дасгалжуулагчдын зөвлөлийг байгуулна.
- 10.2. Хяналтын зөвлөл, ёс зүйн зөвлөл, шүүгчдийн зөвлөл, дасгалжуулагчдын зөвлөлийн эрх үүрэг, үйл ажиллагааны журмыг Удирдах зөвлөл батлана.

Арван нэгдүгээр зүйл. Холбооны удирдах албан тушаалд нэр дэвшигчид тавигдах ерөнхий шаардлага

- 11.1. Удирдах зөвлөлийн гишүүн сагсан бөмбөгийн спортыг дэмждэг, мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан Холбооны эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохино.
- 11.2. Холбооны үндсэн гишүүнийг төлөөлж Удирдах зөвлөлд ажиллах төлөөлөл нь дараах шаардлагыг хангасан байна:
 - 11.2.1. Тухайн байгууллагын удирдах албан тушаалтан /Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхий нарийн бичгийн дарга/ байх;
 - 11.2.2. Сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх чин эрмэлзэл, уралдаан зохион байгуулах дадлага туршлагатай, урьд нь ял шийтгэл эдлэж байгаагүй, Монгол Улсын иргэн байна.
- 11.3. Холбооны Ерөнхийлөгчид болон Дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч нь:
 - 11.3.1. Нийгэмд нэр хүндтэй, Холбооны үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн дэмжлэг үзүүлэх чадвартай, сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, удирдан зохион байгуулах дадлага туршлагатай, урьд нь ял шийтгэл эдлэж байгаагүй Монгол Улсын иргэн байна.
- 11.4. Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч нь:
 - 11.4.1. Сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, гадаад хэлний зохих мэдлэгтэй, гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харьцах харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах, уралдаан зохион байгуулах чадвар, туршлагатай, урьд нь ял шийтгэл эдлэж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

Арван хоёрдугаар зүйл. Холбооны хөрөнгө

- 12.1. Холбоо нь газар, барилга, байшин, орон сууц, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, мөнгөн хөрөнгө, хувьцаа, бусад үнэт цаас болон Холбооны үйл ажиллагааг материаллаг байдлаар хангах бусад эд хөрөнгийг өмчлөлдөө байлгаж болно.
- 12.2. Холбооны өмчлөлд дүрмийн зорилгыг биелүүлэх зорилгоор Холбооны хөрөнгөөр бий болгож олж авсан хэвлэлийн газар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байж болно.
- 12.3. Холбооны хөрөнгө дараах эх сурвалжаас бүрдэнэ.
 - 12.3.1. Монголын Үндэсний Олимпийн хороо болон бусад хуулийн этгээдийн хөрөнгөөс хуваарилсан хөрөнгө;
 - 12.3.2. Монгол Улсад спортын арга хэмжээ болон сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд зориулан хуваарилсан ивээн тэтгэгч, хандивлагчдын хөрөнгө;

- 12.3.3. Холбооны гишүүд, удирдах зөвлөлийн гишүүд болон бусад хувь хүн, хуулийн этгээдээс Холбооны зорилго үйл ажиллагааг дэмжин өгсөн хандив, өглөг;
 - 12.3.4. Холбооны зорилго үйл ажиллагааны чиглэлд нийцсэн аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого, хөрөнгө;
 - 12.3.5. Орон нутгийн болон улсын төсвөөс сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэхэд зориулан төлөвлөсөн хөрөнгө;
 - 12.3.6. Бусад хуулиар хориглогдоогүй арга хэлбэрээр орж ирсэн хөрөнгө.
- 12.4. Холбооны аж ахуй болон бусад үйл ажиллагаанаас олсон орлогыг хуваарилахгүй бөгөөд гагцхүү дүрмийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд зарцуулна.
- 12.5. Холбооны эд хөрөнгийн өмчлөгч нь зөвхөн “Монголын сагсан бөмбөгийн холбоо” НҮТББ байна.
- 12.6. Холбоо нь өөрийн үйл ажиллагааны зорилгод нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхдээ бие даан төлөвлөх бөгөөд аж ахуйн зорилгоор нөхөрлөл болон холбоо, хуулийн этгээд байгуулж эд хөрөнгө олж авах эрхтэй. Холбооны байгуулсан аж ахуйн нөхөрлөл, холбоо болон бусад байгууллагууд нь холбогдох төсөвт Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоосон журам, хэмжээгээр татвар төлнө.
- 12.7. Холбоо нь өөрийн эд хөрөнгийг хүмүүнлэгийн зорилгоор ашиглах эрхтэй.
- 12.8. Холбоо нь аж ахуйн үйл ажиллагааныхаа тайланг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу улирал бүр харьяа татварын байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй.

Арван гуравдугаар зүйл. Холбооны санхүүжилт

- 13.1. Холбоо нь дараах эх үүсвэрээс санхүүжинэ:
- 13.1.1. Улс, орон нутгийн төсвөөс олгосон мөнгөн хөрөнгө;
 - 13.1.2. Дүрмийн зорилгыг хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;
 - 13.1.3. Удирдах зөвлөлийн гишүүдийн тухайн жилийн хандив;
 - 13.1.4. Хувь хүн, гадаад, дотоодын хуулийн этгээд, олон улсын байгууллагын хандив, тусламж;
 - 13.1.5. Өөрийн хөрөнгөө хуулийн дагуу ашиглах явцад орсон орлого;
 - 13.1.6. Хуулиар хориглоогүй бусад арга хэлбэрээр орж ирсэн мөнгөн хөрөнгө.
- 13.2. Холбоо өөрийн хөрөнгө, санхүүжилтийг дүрэмд заасан зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах, захиран зарцуулах эрхтэй.
- 13.3. Холбооны удирдах албан тушаалтнууд нь Холбооны өмч, хөрөнгийг хувийн ашиг олох зорилгоор ашиглах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.
- 13.4. Холбоо нь улс төрийн сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгөхийг хориглоно.
- 13.5. Холбоо жил бүр санхүүгийн тайлан тэнцлээ хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулан Бүх гишүүдийн хуралд танилцуулна.
- 13.6. Холбооны санхүүгийн тайлан нь гишүүдэд ил тод байна.

**Арван дөрөвдүгээр зүйл. Холбооны санхүүгийн
үйл ажиллагаанд тавих хяналт**

- 14.1. Холбооны санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Хяналтын зөвлөл хэрэгжүүлэх бөгөөд Холбооны удирдах байгууллагаас гаргасан шийдвэр, дүрэм журмын биелэлтийг хянаж, шаардлагатай тохиолдолд дотоод шалгалт хийн тайлан дүгнэлтийг Удирдах зөвлөлд танилцуулна.
- 14.2. Хяналтын зөвлөл шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн аудитын байгууллагаар санхүүгийн хяналт шалгалт хийлгэх саналыг Удирдах зөвлөлд оруулан шийдвэрлүүлнэ.

**Арван тавдугаар зүйл. Маргаан шийдвэрлэх болон
сонирхлын зөрчлийг зохицуулах**

- 15.1. Холбоо нь дэргэдээ маргаан таслах хороотой байж болно.
- 15.2. Маргаан таслах хорооны бүрэлдэхүүнийг Удирдах зөвлөл томилно.
- 15.3. Маргаан таслах хорооны ажиллах журмыг Удирдах зөвлөл батлан биелэлтэд хяналт тавьж ажиллана.
- 15.4. Маргаан таслах хорооны шийдвэрийг маргалдагч талууд эс зөвшөөрвөл Олон улсын сагсан бөмбөгийн холбооны дүрмийн дагуу Спортын арбитрын шүүх (CAS)-д гомдлоо гаргах бөгөөд тус шүүхийн шийдвэр нь эцсийнх байх тул заавал дагаж мөрдөнө.
- 15.5. Аливаа зөрчил, маргаан үүссэн үед Холбооны Маргаан таслах хороо тухайн маргааны учир шалтгааныг судалж, хэрхэн шийдвэрлэж болох тухай саналаа Удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ.
- 15.6. Холбооны Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга нь бусад хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулахдаа ашиг сонирхлын зөрчил үүсэхээс зайлсхийх бөгөөд хэрэв ашиг сонирхолын зөрчил үүссэн тохиолдолд Удирдах зөвлөлд мэдэгдэн тухайн хэлцэлийг хийхээс эсхүл санал өгөхөөс татгалзана.
- 15.7. Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл, гэрээг байгуулснаас үүдэн Холбоонд хохирол учирсан бол уг хохиролыг тухайн ашиг сонирхлын зөрчилтэй албан тушаалтан бүрэн барагдуулна.

Арван зургаадугаар зүйл. Холбоог өөрчлөх, татан буулгах

- 16.1. Холбоог Бүх гишүүдийн хурлын төлөөлөгчдийн 2/3-аас доошгүй саналаар, эсхүл хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр буюу шүүхийн шийдвэрээр татан буулгана.
- 16.2. Холбоог нэгтгэх, нийлүүлэх, тусгаарлан өөрчлөн байгуулах шийдвэрийг Бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.
- 16.3. Холбоог татан буулгах тохиолдолд хэрэв зээл олгогчид байсан бол тэдний шаардлагыг хангасны дараа Холбооны үлдэгдэл эд хөрөнгийг дүрмийн зорилгод зарцуулна.

16.4.Холбооны эрх барих дээд байгууллага нь Холбоог татан буулгасан тухай шийдвэрээ 21 хоногийн өмнө олон нийтэд мэдэгдэх бөгөөд энэ шийдвэр нь Холбоог улсын бүртгэлээс хасах үндэслэл болно.

Арван долдугаар зүйл. Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

17.1.Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Удирдах зөвлөл хүлээн авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж, уг асуудлыг Бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлнэ.

17.2.Холбооны дүрмийн өөрчлөлтийг Бүх гишүүдийн хурлаар баталсны дараа уг өөрчлөлтийг дагаж мөрдөнө.

Арван наймдугаар зүйл. Дүрэм хүчин төгөлдөр болох

18.1.Холбооны Дүрэм нь Бүх гишүүдийн хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батлагдсан мөчөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

18.2.Батлагдсан Холбооны дүрмийн хувийг хуулиар заасан хугацаанд Улсын бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

---oOo---